



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2014 оны 07 сарын 16 өдөр

Дугаар 18/588

Улаанбаатар хот


Хөрөнгө оруулалтын ажлыг зохион  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.4, 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны "Нийслэлийн 2014 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай" 18/19 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2014 онд санхүүжих Агаар бохирдуулагч суурин эх үүсвэрүүдэд хэмжилт хийх тоног төхөөрөмжүүдийг суурилуулах зориулалтын 2ш автомашин худалдан авах 162,0 /нэг зуун жаран хоёр сая/ төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулан, худалдан авах ажиллагааг холбогдох хууль журамд нийцүүлэн зохион байгуулахыг нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар /Ю.Идэрцогт/-т даалгасугай.

2. Хөрөнгө оруулалтын ажлыг гүйцэтгэлээр санхүүжүүлэхийг Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /Э.Ганхүү/, захиалагчийн хяналт тавьж ажиллахыг нийслэлийн Агаарын чанарын алба /Ч.Батсайхан/, хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтын байдалд хяналт тавьж ажиллахыг нийслэлийн Өмчийн харилцааны газар /Ш.Төмөрбаатар/-т тус тус даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ



Э.БАТ-ҮҮЛ

111020002434



Гүйцэтгэгч сонгох, гэрээ байгуулах тухай


Монгол Улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 47 дугаар зүйлийн 47.2.2 дахь хэсгийн заалтыг үндэслэн **ЗӨВЛӨХ НЬ:**

Нэг. Тендерийн үнэлгээний хорооны 2014 оны 11 дүгээр сарын 03-ны едрийн хурлын тэмдэглэл, дүгнэлтийг үндэслэн "Агаар бохируудагч суурин эх үүсвэрүүдэд хэмжилт хийх тоног төхөөрөмж суурилуулах зориулалтын 2ш автомашин нийлүүлэх НХААГ-14/0187"-ын гүйцэтгэгчийг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1 дэх заалтын дагуу дараах байгууллагатай гэрээ шууд байгуулахыг Нийслэлийн Агаарын чанарын алба /Ч.Батсайхан/-д зөвлөж байна.

№	Тендер шалгаруулалтын нэр, дугаар	Шалгарсан байгууллагын нэр	Үнийн санал /төгрөгөөр/
1	Агаар бохируудагч суурин эх үүсвэрүүдэд хэмжилт хийх тоног төхөөрөмж суурилуулах зориулалтын 2ш автомашин нийлүүлэх НХААГ-14/0187	"Вагнер ази автоматив" ХХК	162 000 000₮ /нэг зуун жаран хоёр сая төгрөг/

Хоёр. Дээрх байгууллагатай Монгол Улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийн заалтын дагуу гэрээ байгуулан, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллана уу.

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ  
 ДАРГА:



Т.БАТ-ЭРДЭНЭ  
 Нийслэлийн Засаг даргын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч

ГИШҮҮД:



Х.ГАЛЫМБЕК  
 Нийслэлийн Агаарын чанарын албаны дэд дарга



Г.ТЭМҮҮЖИН  
 Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын мэргэжилтэн

З.БОЛДБААТАР  
 "Монголын ногоон хөгжлийн зуун" Төрийн бус байгууллагын гишүүн

НАРИЙН БИЧГИЙН  
 ДАРГА:



Д.БАЯРСАЙХАН  
 Нийслэлийн худалдан авах ажиллагааны газрын мэргэжилтэн



**БАТЛАВ.**

**ЗАХИАЛАГЧ:**

НИЙСЛЭЛИЙН АГААРЫН  
ЧАНАРЫН АЛБАНЫ  
ДАРГА

  
Ч.БАТСАЙХАН

**ГҮЙЦЭТГЭГЧ:**


"ВАГНЕР АЗИ АВТОМОТИВ"  
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ



Ч.МЭРГЭН

**ЗӨВШӨӨРСӨН:**

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

  
Э.ГАНХҮҮ

**Агаар бохирдуулагч суурин эх үүсвэрүүдэд хэмжилт хийх  
тоног төхөөрөмж суурилуулах зориулалтын автомашин нийлүүлэх гэрээ**

**Дугаар № НХААГ-14/0187**

2014 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр

Улаанбаатар хот

Нэг талаас Нийслэлийн Агаарын чанарын алба (цаашид "Захиалагч" тал гэх)-ыг төлөөлж, Хяналт, үнэлгээний хэлтсийн дарга Д.Даваадорж, нягтлан бодогч П.Ариунаа, нөгөө талаас "Вагнер Ази Автомотив" ХХК (цаашид "Нийлүүлэгч" гэх)-ийг төлөөлж, худалдааны хэлтсийн менежер Б.Эрдэнэбаяр нар дараах зүйлийг харилцан тохиролцож, Нийслэлийн Засаг даргын 2014 оны 07 дугаар сарын 24-ны өдрийн А/617 дугаар захирамжаар байгуулагдсан үнэлгээний хорооны зөвлөмжийг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдсон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь агаар бохирдуулагч суурин эх үүсвэрүүдэд хэмжилт хийх тоног төхөөрөмж суурилуулах зориулалтын 2 ширхэг автомашин нийлүүлэх НХААГ-14/0187 дугаартай 162,000,000 /нэг зуун жаран хоёр сая/ төгрөг /цаашид "гэрээний үнэ" гэх/ нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв.  
Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийн 162,000,000 /нэг зуун жаран хоёр сая/ төгрөгийг нийслэлийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь агаар бохирдуулагч суурин эх үүсвэрүүдэд хэмжилт хийх тоног төхөөрөмж суурилуулах зориулалтын 2 ширхэг автомашинийг 2014 оны 11 дүгээр сарын 11-ны өдрөөс 2014 оны 12 дугаар сарын 11-ны дотор нийлүүлж хүлээлгэн өгнө.



5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно. /цаашид "гэрээний баримт бичиг" гэх/ Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл  
Үнэлгээний хорооны зөвлөмж, хурлын тэмдэглэл  
Үнийн санал  
Гэрээний ерөнхий нөхцөл  
Гэрээний тусгай нөхцөл  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь  
Санхүүжилтийн хуваарь


Гэрээ нь энд дурьдсан автомашины нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурьдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан автомашинуудыг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх автомашинууд болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

#### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

##### ЗАХИАЛАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:

НИЙСЛЭЛИЙН АГААРЫН ЧАНАРЫН АЛБАНЫ  
ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА



Д.ДАВААДОРЖ

НЯГТЛАН БОДОГЧ



П.АРИУНАА

ХАЯГ:

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Нийслэлийн төр захиргааны нэгдсэн байр  
Хангарьд ордон, 401 тоот  
Утас: 976-11-314876 /факс: 976-11-32463

##### НИЙЛҮҮЛЭГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:

"ВАГНЕР АЗИ АВТОМОТИВ" ХХК-ийн ХУДАЛДААНЫ  
ТӨЛӨӨЛӨГЧ



Б.ЭРДЭНЭБАЯР

ХАЯГ:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Нарны зам  
55/1, Тээвэрчдийн гудамж  
Утас: 70113673





НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2014 оны 12 сарын 22 өдөр

Дугаар А/1048

Улаанбаатар хот

Тээврийн хэрэгсэл бүртгэн авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.2-ын "а", 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 3.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн нэгдүгээр хавсралтанд заасан 1 530 990 889 /нэг тэр бум таван зуун гучин сая есөн зуун ерин мянга найман зуун наян есөн/ төгрөгийн, Бүгд найрамдах Солонгос улсын Онцгой байдлын газраас хандивласан хоёрдугаар хавсралтанд заасан 22 179 000 /хорин хоёр сая нэг зуун далан есөн мянган/ төгрөгийн үнэ бүхий тээврийн хэрэгслүүдийг данс бүртгэлдээ бүртгэн авахыг Нийслэлийн Агаарын чанарын алба, Чингэлтэй дүүргийн Жижиг дунд үйлдвэрлэл-ийг дэмжих Бизнес инкубатор төв, "Чингэлтэйн Ахмадын амралт" ОНӨААТҮГ, Чингэлтэй дүүргийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс, Замын хөдөлгөөний удирдлагын төв НӨҮГ, Нийтийн Үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл ОНӨААТҮГ, нийслэлийн Онцгой байдлын газрын дарга, захирал нарт даалгасугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг нийслэлийн Өмчийн харилцааны газар /Ш.Төмөрбаатар/-т үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН  
АСУУДАЛ ХАРИУЦСАН  
ОРЛОГЧ

Н.БАТАА

111020004520

Нийслэлийн Засаг даргын 2014 оны  
 2014 оны сарын 14-ны өдрийн 1/1048  
 захирамжийн нэгдүгээр хавсралт

Нийслэлийн өмчид бүртгэх тээврийн хэрэгслийн жагсаалт

№	Херенгийн нэр	Марк	Арлын дугаар	Үйлдвэр- лэсэн он	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Эзэмшигч байгууллагын нэр	Херенгө оруулалтын эх үүсвэр
1	Агаарын бохирдлыг хэмжих тусгай зориулалтын автомашин	FORD TRANSIT VAN	WF0XXXTTG XEU28679	2014	1	81,000,000	81,000,000	Нийслэлийн Агаарын чанарын алба	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
2		FORD TRANSIT VAN	WF0XXXTTG XEU28677	2014	1	81,000,000	81,000,000		
3	Туулах чадвар сайтай суудлын жил автомашин	VOLKS- WAGEN TOUAREG	WVGZG77L8 8D045308	2006	1	29,860,888	29,860,888	Чингэлтэй дүүргийн Жижиг дунд үйлдвэрлэл- ийг дэмжих Бизнес инкубатор төвд	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
4	Суудлын автомашин	TOYOTA ALPHARD	ANH1001- 19816	2005	1	25,000,000	25,000,000	"Чингэлтэйн Ахмадын амралт" ОНӨААТҮГ	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
5	Суудлын автомашин	Hyunday Elentra	KMHHDG41CA EU216345	2014	1	39,000,000	39,000,000	Чингэлтэй дүүргийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
6	Тусгай зориулалтын автомашин	DongFeng	LGAX2B136E 1022211	2014	1	161,025,000	161,025,000	Замын хөдөлгөөний удирдлагын төв НӨҮГ -т	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
7		DongFeng	LGAX2B134E 1022210	2014	1	161,025,001	161,025,001		

